



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/213

Улаанбаатар хот

Хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.19, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 16.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өндөр барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг нэгдүгээр, “Рашаан, сувиллын газрын галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг хоёрдугаар, “Эрчим хүчний барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийхдээ батлагдсан хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа ашиглан ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын газрын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ




Г.АРИУНБУЯН

1426011982



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 16 дугаар сарын 16-ны өдрийн
16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ӨНДӨР БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналтыг хэрэгжүүлэх салбар, нэгж:	
Шалгуулагч этгээдийн нэр:	
Регистрийн дугаар:	
Объектын нэр, хаяг, солбилцол:	
Байгуулагдсан огноо:	
Үйл ажиллагааны чиглэл:	
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/- ын нэр, холбоо барих утасны дугаар:	

2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан эсэх		Тайлбар	Гүйцэтгэл ийн хяналт шалгалт
			Тийм	Үгүй		
1	2	3	4	5	6	
1	Барилгын тухай хуулийн 14-р зүйл.	Барилга байгууламж ашиглалтад орсноос хойш зүгшрүүлэх, тохируулах хуулийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан нар барилга байгууламжийн техник тоног төхөөрөмж, аюулгүй байдал хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан тэмдэглэл үйлдэн баталгаажуулсан эсэх.				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18-р зүйл	Барилга байгууламжид гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбайтай эсэх.				
3	Хот байгуулалтын тухай хуулийн 12-р зүйл	Орон сууц, олон нийтийн барилга болон үйлдвэр, үйлдвэрийн туслах барилга байгууламжийн				

		хоорондын гал тусгаарлах зай хангагдсан эсэх.				
4	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 6.34-р зүйл	Барилгын даацын ган бүтээцийг заавал галаас хамгаалсан байх шаардлагатай. Галаас хамгаалах арга хэмжээг шалгахад зориулж шалгалтын шагайвчтай эсэх.				
5	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 10.6-р зүйл	Барилгын зорчигчдын цахилгаан шатны бүлэгт гал унтраагчдыг зөөх 1-2 ш цахилгаан шат төлөвлөсөн эсэх.				
6	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 12-р зүйл	Цахилгааны дэд өртөөнөөс галын хэсэг бүрт байрлах оролтын хуваарилалтын төхөөрөмжүүд рүү бие даасан тэжээлийн шугам татсан эсэх.				
7	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 12.11-р зүйл	Барилгад ажлын болон ослын гэрэлтүүлэг төлөвлөсөн эсэх.				
8	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.4-р зүйл	Өндөр барилгаас 500 м-ээс холгүй зайд аварсан хүмүүсийг нисдэг тэргээр зөөж хүргэх талбай төлөвлөгдсөн эсэх.				
9	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.47-р зүйл	Утаанаас хамгаалах даралттай агаар өгөх, утаа зайлуулах систем хэвийн ажиллагаатай эсэх.				
10	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.73-р зүйл	Галын автомат мэдээлэгч нь бүх төрлийн ерөө тасалгаанд тавигдсан, ажиллагаа хэвийн эсэх.				
11	Өндөр барилгын төлөвлөлт БНБД 31-17-10-ын 14.93-р зүйл	Гал түймэр унтраах шуурхай ажиллагааны төлөвлөгөөг барилга барих үеийн болон ашиглалтын үеийн гэж тусад нь зохиож галын төв байгууллагаар батлуулсан эсэх.				
12	Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл БНБД 21-04-05	Гал унтраах автомат төхөөрөмж, гал мэдээллэх дохиоллын хэрэгсэл хэвийн ажиллагаатай эсэх.				
13	Галын аюулгүй байдлын үндсэн	Барилга байгууламж, барилга хоорондын гал эсэргүүцэх зайд тоног				

	дүрмийн 6-р зүйл.	төхөөрөмж, чингэлэг, эд зүйл байрлуулж ашигладаг эсэх				
14	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 7-р зүйл.	СӨХолбооны ажилтан албан хаагчдыг галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалтад хамруулдаг эсэх.				
15	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.17-р заалт.	Барилга байгууламжийн гадна байрлах галын гидрант, галын шат, гал унтраах багаж хэрэгсэл шөнийн цагт ашиглахад зориулсан гэрэлтүүлэгтэй эсэх.				
16	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.19-р заалт.	Гал унтраах усан хангамжийн сүлжээний ажиллагааг жилд хоёроос доошгүй удаа (хавар, намар) шалгаж, ашиглалтын бэлэн байдлыг хангуулсан эсэх.				
17	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.22-р заалт.	Гал түймэр унтраах усан хангамжийн эх үүсвэрт жилийн аль ч улиралд саадгүй очих зам, гарцтай эсэх.				
18	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.24, 8.26-р заалт.	Барилгын гадна, доторх гал түймэр унтраах усны сүлжээ, цахилгаан эрчим хүч, ус шахах шугам сүлжээний бэлэн байдлыг хангуулсан эсэх.				
19	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.27-р заалт	Барилга дотор гал унтраах даралтат усны цэг "ГК"-ийн хайрцаг, хоолой хошууны бэлэн байдлыг хангуулсан эсэх.				
20	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.47-р заалт	Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан үед мэдээлэх дуут болон гэрлэн дохио, аврах зам, гарцын гэрлэн дохио, хаалга, зам гарц, аврах үйл ажиллагааны техник хэрэгслийг техникийн үндсэн бичиг баримтад тусгасан засвар үйлчилгээний хугацаа, үзлэгийн хуваарь, гэрээ, зөвшөөрлийн бичигт заасан хугацаанд техникийн үйлчилгээ,				

		урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг хийж, энэ талаар тэмдэглэл үйлддэг эсэх.				
21	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.54-р заалт Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10-ын 4.14-р заалт	Автоматаар ажилладаг (асаах төхөөрөмж) галын дохиолол, утаа эсэргүүцэх системийн удирдлагын самбарын төхөөрөмжийг ашиглалтын баримт бичигт тусгайлан заагаагүй бол гараар ажиллах горимд шилжүүлэхгүй байх. Орон сууцны техникийн давхарт батлагдсан зураг төслөөс бусад чиглэлээр өрөө тасалгаа төлөвлөгдсөн эсэх.				
22	Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт БНБД 31-01-10-ын 5.4-р заалт	Орон сууцны барилгын тагт, лоожийн аврах гарцыг хааж, бараа материал хураасан эсэх.				
23	Хийн хангамж БНБД 42-01-19 дүрмийн 9.49	Орон сууцны хоёроос дээш давхар бүхий барилга дотор хийн баллон байрлуулахыг хориглоно				
24	Авто зогсоол БНБД 21-05-10	Зоорийн давхрын автозогсоолыг батлагдсан байгуулалтын зураг төслөөс өөрчлөлт оруулан зогсоол давхардуулан орох, гарах гарц, урсгалын хөдөлгөөн хязгаарлан автомашиныг байрлуулсан эсэх.				
25	Авто зогсоол БНБД 21-05-10	Зоорийн давхрын авто зогсоолын гал унтраах автомат систем, дулаан мэдрэгч, агаар сэлгэлтийн систем ажиллагаатай эсэх.				
26	Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007 стандартын 4.7	Зогсоолын эгнээний хооронд тээврийн хэрэгслийн хөдөлгөөн чөлөөтэй нэвтрэх замтай байна. Эгнээний хоорондын хөдөлгөөнийг хааж, автомашин байрлуулахыг хориглоно гэсэн стандартын заалтуудыг зөрчиж, зам гарц хааж авто тээврийн хэрэгсэл байрлуулахгүй байх гэсэн шаардлагыг хангаж байгаа эсэх				

27	Автозогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага MNS 5342:2007 стандартын 7.7	Зогсоолын авто тээврийн хэрэгсэл байрлах байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар тэмдэглэсэн эсэх				
28	Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS5566:2020	Объект, барилга байгууламжид байх гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн ерөнхий нормын дагуу төлөвлөсөн эсэх.				

Тайлбар: Хяналт шалгалтын хуудсанд давхацсан асуултыг харьяалах хуулийн заалтын дагуу шийдвэрлэнэ.


3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

<i>Хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>
<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>
<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>

ТАЙЛБАР:

.....

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2026 оны 16 дугаар сарын 15-ны өдрийн
 А... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
 /a13



РАШААН, СУВИЛЛЫН ГАЗРЫН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ШАЛГАХ
 ХЯНАЛТЫН ХУУДАС

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналт шалгалт хийх байгууллага	
Шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн нэр	
Регистрийн дугаар	
Дарга, захирал /иргэн, менежер/-ын нэр, холбоо барих утасны дугаар:	
Хяналт шалгалтын төрөл	
Хяналт шалгалт хийсэн огноо	

2.ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГЛЭЛ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан эсэх		Тайлбар	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Хангасан	Хангаагүй		
1	2	3	4	5	6	
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.2	Аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгасан байдал				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримталсан эсэх				
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх				

4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10	Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан эсэх				
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.3	Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэл хөтөлсөн эсэх				
6	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.3	Гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбайтай байхаар төлөвлөсөн эсэх				
7	Амралтын газар жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартын 4.5.3.2, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.5	Барилга байгууламжид галын аюулын таних тэмдэг, гал түймэр гарсан үед гарах аврах зам, гарцын төлөвлөлтийн зургийг харагдахуйц газар байрлуулсан эсэх				
8	Амралтын газар жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартын 4.5.3.3,	Зочны байр, гэр, гадна талбайн орчинд галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж тавьсан эсэх				
9	Амралтын газар жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартын 4.5.3.7	Барилга байгууламжийн хонгил, шатны эргэх хэсэг, олон нийтийн танхим, зочны байрыг галд тэсвэртэй материалаар хийсэн эсэх				
10	Амралтын газар жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартын 4.5.3.8	Аянга газардуулагчтай эсэх /аянга газар дуулагчийг мэргэжлийн байгууллагаар шалгуулсан байх/				
11	Амралтын газар жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019 стандартын 4.5.3.10	Галын аюулгүй байдлаа хангах зорилгоор гал унтраах дараах усны нөөцтэй байна. Үүнд: -15 хүртэлх гэртэй, 5 хүртэлх объектод, галд тэсвэрлэлтийн III зэрэг бол – 5тн, -5 хүртэл объектод, 30 хүртэлх гэртэй, галд тэсвэрлэлтийн III зэрэг бол – 10тн,				

		-5 хүртэлх объекттой, галд тэсвэрлэлтийн II бол – 15тн,			
12	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.6	Барилга байгууламжид гал түймэр гарсан үед мэдээлэх холбоо, дохиоллын хэрэгсэлтэй эсэх			
13	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.36.1	Аврах зам, гарц, хаалгыг хааж (хонгил, гарц, үүдний өрөө, цахилгаан шатны талбай, шатны тавцан, дээвэрт гарах гарц, хаалга зэргийн) төрөл бүрийн хог хаягдал, бараа материал, эд зүйл хураах, тоног төхөөрөмж байрлуулах, хаалгыг онгойхгүйгээр бэхэлсэн эсэх			
14	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.11.1	Дамжуулагчийн тусгаарлагч нь шалбарч гэмтсэн, ашиглалтын явцад тусгаарлах чанараа алдсан шугам, дамжуулагч утсыг ашигласан эсэх			
16	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.11.5, 4.11.6	Цахилгаан гүйдэл бүхий кабель шугам, дамжуулах утасны хамгаалалтгүй үзүүрийг ил орхих, гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашигласан эсэх			
17	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 8.27	Барилгын доторх галын гидрант (галын кран) нь байнгын даралттай, стандартад нийцсэн хайрцаг сав, хоолой, хушуутай байна. Хоолой нь усны шугам, галын хушуунд холбоотой байх бөгөөд эвхэлтийг жилд 1-ээс доошгүй удаа солино.			
18	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.21	Хийн баллон хадгалах тусгай сав нь цоожтой, агаар сэлгэлтийн хавхалгатай байх бөгөөд "Галын аюултай. Шатдаг хий" гэсэн анхааруулах тэмдэгтэй байрлуулсан байна.			
19	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.24	Хийн тулгыг 2.2 метрээс дээш өндөр таазтай, агаар сорох суваг болон салхи оруулах цонхтой галлагаа хэрэглэдэггүй байранд барилгын халаах хэрэгслээс 1 метр, цахилгаан халаагчаас 3 метр зайтай байрлуулна.			
20	MNS5566:2020 стандарт 8.1	Гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийг стандартад зааснаар байрлуулсан эсэх			
21	MNS5566:2020 стандарт 8.7	Гал унтраагуурын савны дээд хэсэг нь шалны түвшингээс дээш 1,35м хүртэлх өндөрт байхаар тооцон хананд бэхэлж хүмүүсийн хөдөлгөөнд саад болохгүй, авч хэрэглэхэд хялбар, нарны шууд			

		тусгал тусахааргүй газар байрлуулсан эсэх				
22	MNS5566:2020 стандарт 8.8	Галын саравчинд хамгаалж буй объектын галын аюулын байдал, талбайн хэмжээнээс хамааруулан сүх, хүрз, дэгээ, хувин, царил, элстэй сав (0,5м3 багтаамжтай) тус бүр 1 ширхэг, галд тэсвэртэй бүтээлэг (1х1-2х2м2 хэмжээтэй) 2шээс багагүй байрлуулсан эсэх				

Хяналт шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт
Гүйцэтгэлийн шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт

3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

<i>Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>
<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>
<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>

Тайлбар:.....

.....

.....

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
 А. дугаар тушаалын гуравдугаар хавсралт
 /213



ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ГАЛЫН АЮУЛГҮЙ
 БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Хяналт шалгалт хийх байгууллага	
Шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн нэр	
Регистрийн дугаар	
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар:	
Хяналт шалгалтын төрөл	
Хяналт шалгалт хийсэн огноо	

2.ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЧИГЛЭЛ:

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шардлага хангасан эсэх		Тайлбар	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Хангасан	Хангаагүй		
1		2	3	4	5	6
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3-р заалт	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримталсан эсэх /төвөгшлийн ангиллаас хамаарна/				
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4-р заалт	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх				

3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6-р заалт	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангасан эсэх				
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10-р заалт	Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж эрх бүхий этгээдээр баталгаажуулсан эсэх				
5	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.2-р заалт	Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн байгууллагын барилга байгууламж, объектын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах дотоод зааврыг объект тус бүрээр баталж мөрдүүлж Галын аюулгүй байдлыг хангах дотоод зааварт дараах асуудлыг тусгасан эсэх				
6	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.7-р заалт	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн байршлыг тухайн байгууламжийн төлөвлөлтийн зурагт тусгасан эсэх				
7	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 3.6-р заалт	Аврах зам, гарцын гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь цахилгаан тасармагц ослын тэжээлээс (өөр эх үүсвэрээс) тэжээгдэн автоматаар асч байхаар тоноглогдсон байна.				
8	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.4-р заалт	Аянгийн хүчтэй үйлчлэлийн бүсэд байрласан барилга байгууламж нь барилгын норм, дүрмийн шаардлагыг хангасан аянгаас хамгаалах төхөөрөмжөөр тоноглогдсон эсэх				
9	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.11.1-р заалт	Дамжуулагчийн тусгаарлагч нь шалбарч гэмтсэн, ашиглалтын явцад тусгаарлах чанараа алдсан шугам, дамжуулагч утсыг ашигласан эсэх				
10	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.11.2-р заалт	Цахилгаан гүйдэл бүхий кабель шугам, дамжуулах утасны хамгаалалтгүй үзүүрийг ил орхисон эсэх				
11	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.11.5, 4.11.6 дахь заалтууд	Цахилгаан гүйдэл бүхий кабель шугам, дамжуулах утасны хамгаалалтгүй үзүүрийг ил орхих, гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашигласан эсэх				
12	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 4.11.9-р заалт	Цахилгааны хянах самбар, цахилгаан хөдөлгүүр, асааж унтраах аппаратын дэргэд шатамхай (хялбар авалцан асах) бодис, материал байрлуулах, хураасан эсэх				

13	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.17-р заалт.	Барилга байгууламжийн гадна байрлах галын гидрант, галын шат, гал унтраах багаж хэрэгсэл шөнийн цагт ашиглахад зориулсан гэрэлтүүлэгтэй эсэх.				
14	Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн 8-р зүйл, 8.47-р заалт	Гал унтраах автомат систем, дохиолол, утаа зайлуулах систем, гал гарсан үед мэдээлэх дуут болон гэрлэн дохио, аврах зам, гарцын гэрлэн дохио, хаалга, зам гарц, аврах үйл ажиллагааны техник хэрэгслийг техникийн үндсэн бичиг баримтад тусгасан засвар үйлчилгээний хугацаа, үзлэгийн хуваарь, гэрээ, зөвшөөрлийн бичигт заасан хугацаанд техникийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг хийж, энэ талаар тэмдэглэл үйлддэг эсэх.				
15	Цахилгаан байгууламжийн дүрэм (43-101-03)-ийн 2.1.8, 2.1.9 дэхь заалтууд	Тухайн барилга байгууламжийн шугам сүлжээний угсралт, цахилгаан тоног төхөөрөмжийн төлөвлөлт нь галын аюулгүй байдлыг хангаж байгаа эсэх Цахилгаан утас ба кабелийн салбарлага, холболтыг шахуурга, гагнуур, гагнаас, гагнаас буюу боолтон хавчаар зэргийг ашиглан мөрдөж байгаа "Цахилгаан техникийн ажил БНБД 3 05.06.90-ийн дагуу гүйцэтгэнэ. Дамжуулах утас ба кабелийн салбарлага, холболтыг хийдээ залгалтын судлыг дахин хийж болзошгүй байдлыг тооцож, нөөцтэй тайрахаас гадна үзлэг, засвар хийх боломжтой байвал Зохино.				
16	Аж ахуй Нэгж, Объект, байгууллага, байгууламжид барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх барилга байх гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн ерөнхий нормын дагуу төлөвлөсөн эсэх. шаардлага, норм MNS5566:2020	Объект, барилга байгууламжид байх барилга байх гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн ерөнхий нормын дагуу төлөвлөсөн эсэх.				

17	MNS GOST R 12.2.143:2013	Гарах замын гэрэлтүүлэг нь цахилгаан тасарсан үед ч ажилладаг нөөц эрчим хүчтэй эсэх				
----	-----------------------------	--	--	--	--	--

Хяналт шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт
Гүйцэтгэлийн шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт

3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

<i>Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>	<i>Хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг</i>
<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>	<i>/ албан тушаал /</i>
<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>	<i>/ овог, нэр /</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг /</i>

Тайлбар:.....

.....

.....